



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.09.30 - 10.04

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай хаагдсан ба урт хугацаатай бондын өгөөж буурсан нь эдийн засгийн идэвх буурсны илрэл боллоо. Nasdaq Composite индексийн сагсанд багтах Apple гэх мэт мэдээлэл технологийн компаниудын хувьцааны ханшийн өсөлт тус индексийг дэмжсэн байна. Харин эрчим хүчний компаниудын хувьцааны ханш ихээхэн уналттай байсан нь тус салбарын компаниудын өсөлтөд хөрөнгө оруулагчид санаа зовниж байгаагийн илрэл ба газрын тосны үнийн уналтад нөлөөлөв.

ISM агентлагаас 9-р сарын үйлдвэрлэлийн идэвхийг мэдээлжээ. ISM-ийн үйлдвэрлэлийн индекс 2009 оноос хойших хамгийн бага төвшинд хүрсэн ба ISM-ийн үйлдвэрлэлийн бус индекс сүүлийн 3 жилийн хамгийн доод төвшинд хүрчээ. Гэхдээ, өнгөрөгч хугацаанд Холбооны нөөцийн сангаас богино хугацааны бодлогын хүүг удаа дараа бууруулсан нь тус индексүүд буурснаас үүдэх сөрөг нөлөөг бууруулсан байна. Шинжээчид Холбооны нөөцийн сан, 10-р сарын 29-30 өдрүүдэд зохион байгуулагдах мөнгөний бодлогын уулзалтаар бодлогын хүүг дахин бууруулна гэж үзэж байна.

Энэ долоо хоногт эдийн засгийн мэдээллүүдээс гадна, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллүүд нийтлэгдлээ. АНУ-ын ажилгүйдлийн төвшин 9-р сарын байдлаар 3.5% байгаа нь сүүлийн 50 жилийн хамгийн доод төвшин ч дундаж цалин сүүлийн сартай харьцуулахад нэмэгдээгүй байна.

Европ: Европын холбооны улсуудаас импортоор оруулж ирдэг зарим бүтээгдэхүүнүүдэд АНУ гаалийн татвар ногдуулах болсон мэдэгдэл болон Европын холбооны улсуудын эдийн засгийн үзүүлэлтүүд сул байсантай холбоотой бүс нутгуудыг бүхэлд нь хамарсан STOXX Europe 600 индекс болон экспорт давамгайлсан ХБНГУ-ын DAX индексүүд 3% буурсан бол Их Британи улсын FTSE 100 индекс 3.65%-ийн уналт үзүүлжээ.

Их Британи улс болон Европын холбооны бусад орнуудын энэ сарын эдийн засгийн үзүүлэлтүүдээс үзэхэд тус улсуудын үйлдвэрлэлийн салбарын уналт нь үйлчилгээний салбарт сөргөөр нөлөөлж эхэлжээ. Их Британи улсын үйлчилгээний салбарын индекс 50-аас буурсан ба тус улсын эдийн засгийн 80% нь үйлчилгээний салбараас бүрддэгтэй холбоотой Их Британи улсын төв банкнаас эдийн засгийг дэмжихийн тулд бодлогын хүүг бууруулах магадлалтай байна.

Европын холбооны улсуудаас импортоор орж ирдэг бяслаг, дарс болон иргэний агаарын тээврийн онгоцнууд гэх мэт багаануудад АНУ 25%-ийн гаалийн татвар ногдуулна хэмээн мэдэгджээ. Энэхүү мэдэгдэл нь Европын холбооны зарим улсуудын Засгийн газраас Боинг компанийн өрсөлдөгч Айрбус компанид дэмжлэг үзүүлсэнтэй холбоотой юм.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай хаагдлаа. АНУ болон БНХАУ-ын худалдааны маргаан болон дэлхийн эдийн засгийн удаашралтай холбоотой Япон улсын үйлдвэрлэлийн салбар уналттай байгаа ба экспортын хэмжээ 9 дэх сардаа дараалан буурлаа.

Япон улсын арилжааны банкууд сөрөг хүүтэй холбоотойгоор илүү эрсдэлтэй зээл олгож байгаа нь муу зээлийн зардал өсөх шалтгаан болж байна.

БНХАУ: БНХАУ үүсгэн байгуулагдсаны 70 жилийн ойтой холбоотой БНХАУ-ын биржүүд 10 сарын 8-ны өдрөөс ажиллаж эхлэх юм. АНУ болон БНХАУ-ын эрх баригчид 10-р сарын 10-11 өдрүүдийн хооронд худалдааны асуудалтай холбоотойгоор уулзалт зохион байгуулах ба энэхүү уулзалттай холбоотойгоор 10-р сарын 8-аас биржүүд ажиллаж эхлэхэд хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөх хандлагатай байгаа юм.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,182.47	1.09% ▲
Dow Jones	АНУ	26,573.72	-0.92% ▼
S&P 500	АНУ	2,952.01	-0.33% ▼
Nasdaq	АНУ	7,982.47	0.54% ▲
S&P/TSX	Канад	16,449.35	-1.47% ▼
FTSE 100	Их Британи	7,155.38	-3.65% ▼
S&P/ASX 200	Австрали	6,517.10	-2.96% ▼
Nikkei 225	Япон	21,410.20	-2.14% ▼
Hang Seng	Хонг Конг	25,821.03	-0.52% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.45
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	101.56
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	100.36
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.25
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.07
DBM' 2023	USD	7.250%	104.40
TDBM' 2020	USD	9.375%	102.60
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	98.58

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.978	-0.05 ▼
Libor 3M	2.027	-0.07 ▼
Libor 6M	1.951	-0.11 ▼
Libor 1YR	1.853	-0.19 ▼
US 2YR Bond	1.378	-0.25 ▼
US 3YR Bond	1.334	-0.24 ▼
US 5YR Bond	1.323	-0.24 ▼
US 10YR Bond	1.507	-0.17 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.10.04	Өөрчлөлт
USD	2,667.70	0.00% ▲
CNY	373.19	-0.35% ▼
EUR	2,919.80	0.24% ▲
RUB	40.96	-1.11% ▼
KRW	2.21	-0.90% ▼
JPY	24.88	0.57% ▲
CAD	2,002.03	-0.42% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,504.66	0.51% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	17.55	0.04% ▲
Зэс	USD/lb.	256.25	-1.35% ▼
Нүүрс	USD/MT	67.32	-3.58% ▼
WTI газрын тос	USD/bbl.	52.81	-5.54% ▼
Brent газрын тос	USD/bbl.	58.37	-5.72% ▼

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. VIII	8.90%
Бодлогын хүү	2019. VIII	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. VIII	11.26%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. VIII	11.42%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. VIII	4.99%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. VIII	16.94%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. VIII	10.75%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 53 компанийн 248.4 сая төгрөгийн 1,471,814 ширхэг хувьцаа арилжаалагдав.


“Авто импекс” /AOI/ компанийн хувьцаа 35.29%-аар буюу хамгийн ихээр өсөж 1,725.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Бүтээлч үйлс” /BLC/ компанийн хувьцаа 14.98%-аар буурч 1,271.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 960 ширхэг үнэт цаас 97.0 сая төгрөгөөр арилжаалагджээ.

10-р сарын 04-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,484.2 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,182.47 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.09%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	345.4
Зах зээлийн үнэлгээ	2,484,161.1

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,182.47	1.09% ▲
MSE I индекс	9,026.93	1.77% ▲
MSE II индекс	7,532.13	0.40% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Ард кредит ББСБ	819,849	61,533,797
Инвескор ББСБ	22,15	42,052,390
Говь	133,547	37,121,263
Улсын их дэлгүүр	27,057	21,649,935
Монос хүнс	186,654	11,087,524

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Авто импекс	1,725.00	35.29% ▲
Бөөний худалдаа	450.00	30.43% ▲
Булган гурил тэжээл	920.00	15.00% ▲
Тавилга	1,825.00	15.00% ▲
Ариг гал	3,600.00	12.50% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Бүтээлч үйлс	1,271.00	-14.98% ▼
Өндөрхаан	1,390.00	-14.98% ▼
Стандарт проперти групп	145.00	-14.71% ▼
Адуун чулуун	1,280.00	-14.67% ▼
Монинжбар	100.00	-13.04% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард Секюритиз	135,509,307
Мирэ Эссет Секьюритис Монгол	109,404,523
Централ Секьюритийз	97,584,630
Бумбат-Алтай	74,097,068
Би Ди Сек	49,435,178

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	509.00	541,668
Таван толгой	6,590.00	347,064
МИК Холдинг	14,390.00	298,007
Говь	275.10	214,609
Инвескор ББСБ	1,994.00	143,025

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	960	96,979,200	101,020	101,020	156	15.140%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дүти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.12-с
33	SUU	Сүү ХК	5,706.4	1,143.4	20.0%	3.3	2019.09.09	2019.04.05	2019.09.09-с

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Сүүлийн 3 жилийн хамгийн бага дүнтэй арилжаа хийгдсэн байна

2019 оны 10-р сарын 4-ний баасан гарагт МХБ дээр 124,805 ширхэг хувьцаа арилжигдаж 15.6 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь сүүлийн 3 жилийн хамгийн бага үзүүлэлт боллоо. Сүүлд, 2017 оны 2 сард мөн үзүүлэлтээс бага дүнтэй арилжаа зах зээл дээр хийгдэж байжээ.

Үнэт цаасны ангиллын хувьд I ангилалд 8 компанийн 22,235 ширхэг хувьцаа 5.5 сая төгрөгөөр арилжаалагдсан бол II ангилалд 12 компанийн 101,975 ширхэг хувьцаа 9.3 сая төгрөгөөр, үнэт цаасны III ангилалд 4 компанийн 595 ширхэг хувьцаа 867,000 төгрөгөөр арилжаалагдав.

Хөрөнгө оруулагчдын хооронд 99 удаагийн хэлцэл явагдснаас Говь /MSE:GOV/ ХК дээр 17 хэлцэл хийгдсэн байна.

Эх сурвалж: MarketInfo.mn

“Атар өргөө” ХК-ийн жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх зөрчигдөж байна

МХБ-ийн үнэт цаасны II ангилалд бүртгэлтэй Атар өргөө /MSE:ATR/ ХК сүүлийн 2 жилийн хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулаагүй байна.

Энэ нь хувьцаа эзэмшигчдийн тэр дундаа жижиг хувьцаа эзэмшигчид компанийн тухай хуулиар олгогдсон бүрэн эрхээ эдэлж чадахгүй байна гэсэн үг.

Одоогоор тус компанийн 80.06% нь 3 том хувьцаа эзэмшигчийн мэдэлд байгаа бол үлдсэн 19.94% нь 350 гаруй жижиг хувьцаа эзэмшигчдэд байна. Гэвч том хувьцаа эзэмшигчид хоорондоо зөрчилтэй байгаа.

Уг асуудал 2017 онд “Таванбогд трейд” болон “Улаанбаатар гурил” ХХК худалдан авч, тухайн үеийн компанийн удирдлагуудыг шүүхэд өгснөөс үүдэлтэй. Учир нь компанид хийсэн аудитын шалгалтаар их хэмжээний санхүүгийн зөрчил илэрсэн гэж мэдээлсэн.

Энэ нь хувьцааны арилжааг нь зогсооход хүргэж байсан удаа бий. Тодруулбал 2016 оны санхүүгийн тайланд аудит хийсэн “Фискал аудит” ХХК-ийн зөвлөмж, тус компанийн хүсэлтийг үндэслээд СЗХ-ноос 2017 оны 2-р сарын 24-ний өдрөөс түр хугацаагаар зогсоож мөн оны 12 сард эргэн сэргээж байсан юм.

Уг асуудал хэдий болтол үргэлжилэх эсэх нь тодорхойгүй, компани дахь нөхцөл байдал ямар байгаа талаар компанийн зүгээс болон жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэй Санхүүгийн Зохицуулах Хорооны зүгээс ч, Монголын хөрөнгийн биржээс ч мэдээлэл өгөхгүй байсаар байна.

Эх сурвалж: MarketInfo.mn

“Баялаг Сүмбэр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Баялаг Сүмбэр” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2019 оны 9-р сарын 30-ны өдрийн 19/9-2 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2019 оны 11-р сарын 18-ны өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Бүртгэх өдөр: 2019.10.21-ний өдөр

Хуралдах газар: Хан-Уул дүүрэг, 15 хороо, Мандал хотхон, 42-11

Хурлаар хэлэлцэх асуудал: ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Хурал зохион байгуулах коммисын бүрэлдэхүүн: Гүйцэтгэх захирал Хе Жинвен, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т. Баярмаа

Эх сурвалж: “Ти Ди Би Капитал” ҮЦК

“Хөсөг трейд” ХК-ийн том хөрөнгө оруулагчид хувьцаагаа цуглуулж байна

Монголын Хөрөнгийн Биржийн III ангилалд бүртгэлтэй Хөсөг трейд /MSE:HSG/ ХК-тай холбоотой анхаарал татахуйц зүйл ажиглагдах болжээ.

Тодруулбал, компанийн томоохон хувьцаа эзэмшигчдийн эзэмшил хувь хэмжээ өнгөрөгч 8-р сард 94.59% байсан бол энэ сард 94.76% болж нэмэгдэв. Энэ нь компанийн томоохон хөрөнгө оруулагчид, олон нийтэд байгаа хувьцааг цуглуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгааг харуулж байна.

Гэхдээ энэхүү үйл ажиллагаа нь хөрөнгийн биржийн арилжаагаар бус, сүүлийн үед анхаарал татаж буй биржийн бус хэлцэлээр дамжин хийгдэж байгааг онцлох нь зүйтэй.

Биржийн бус хэлцэл гэдэг нь бэлэглэл болон үүргийн гүйцэтгэл хангуулах зэрэг хэлбэрээр хувьцааг нэг этгээдээс нөгөөд шилжүүлэхийг хэлдэг.

Хувьцааны арилжааны тухайд, хамгийн сүүлд энэ оны 3-р сард Монголын хөрөнгийн бирж дээр 1 ширхэг хувьцаа арилжигдсан ба ханш нь 1,901 төгрөг дээр хаагджээ.

2019 оны 10-р сарын 4-ний өдрийн байдлаар нийт хувьцааны 94.76% нь 5 том хувьцаа эзэмшигчийн мэдэлд байгаа бол үлдсэн 5.24% нь 100 орчим жижиг хувьцаа эзэмшигчийн мэдэлд байгаа ба цаашид энэ тоо нь буурах магадлалтай байна.

Хөсөг трейд компанийн хувьд 1992 онд хөрөнгийн биржид бүртгэгдэж байсан. Одоогоор компани Баянгол дүүрэгт байрлах өөрийн үл хөдлөх хөрөнгийг түрээслэдэг бөгөөд Авто тээврийн үндэсний төвийн харъяа Тээврийн хэрэгслийн оншилгооны төв түрээслэн байршдаг байна.

2019 оны эхний хагас жилийн байдлаар 185.3 сая төгрөгийн орлого олж, 49.4 сая төгрөгийн алдагдалтай буюу нэгж хувьцаандаа 166.98 төгрөгийн алдагдалтай ажилласнаа тайлагнасан байна.

Эх сурвалж: MarketInfo.mn



МХБ: Хувьцаат компаниудын үүргийн хэрэгжилт хангалтгүй байна

Монголын Хөрөнгийн Биржээс бүртгэлтэй хувьцаат компаниудынхаа хууль, журмын хэрэгжилтийн талаар судалгааг 2019 оны эхний хагас жилийн байдлаар гаргасан байна.

Судалгаанаас харахад 177 хувьцаат компанийн 55 нь буюу 31% нь хангалттай биелүүлсэн гэж үзсэн бол 69% нь хангалтгүй, бүрэн бус гэжээ.

Тухайлбал, дээрх компаниудаас 131 хувьцаат компани нь 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа зарлан хуралдуулсан бол 46 хувьцаат компани хурлаа хийлгүй хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдынхаа эрх ашгийг зөрчсөн байна.

Мөн компанийн мэдээлэл бүхий цахим хуудастай эсэх үзүүлэлтийг харвал ердөө 35% л өөрийн цахим хуудастай байгаа аж. Гэхдээ эдгээр компаниудаас хувьцаа эзэмшигчдэдээ тогтмол мэдээлэл хүргэдэг, тогтмол ажиллагаатай сайт нь цөөн хувийг эзлэдэг юм.

Эх сурвалж: MarketInfo.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Монголбанк эхний 9 сарын байдлаар 11.2 тонн алт худалдан авлаа

Монголбанк 2019 оны эхний 9 сард 11.2 тонн үнэт металл худалдан авсан нь өмнөх оны мөн үед 14.3 тонн үнэт металл худалдан авснаас 3.1 тонноор бага буюу 22%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Монголбанк 2019 оны 9 дүгээр сард 1.4 тонн үнэт металл худалдсан авсан ба үүнээс Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 31.4 кг үнэт металл, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 104 кг үнэт металлыг худалдаж авсан нь өмнөх оны мөн үед 2.1 тонн үнэт металл худалдан авч байснаас 694 кг-аар буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны 9 дүгээр сард 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 129,726.23 төгрөг байлаа.

Эх сурвалж: Montsame.mn



Ургац хураалт 25.1 хувьтай байна

Аравдугаар сарын 1-ний байдлаар 43.3 мянган га-г ангилан хадаж нийтдээ 87.7 мянган га-гаас 113.0 мянган тонн үр тариа хураан аваад байна.

Үүнээс 105.7 мянган тонн улаанбуудай, 11.2 мянган га газраас 131.1 мянган тонн төмс, 4.6 мянган га газраас 51.1 мянган тонн хүнсний ногоо тус тус хураан аваад байна. Ингэснээр үр тарианы хураалт 25.1 хувь, хүнсний ногооны хураалт 58.1 хувь, төмсний хураалт 75.1 хувьтай байгаа талаар ХХААХҮЯ-наас мэдээлж байна.

Энэ онд улсын хэмжээнд 364.8 мянган га газарт үр тариа, үүнээс 340 мянган га газарт улаанбуудай, 14.8 мянган га газарт төмс, 8.0 мянган га газарт хүнсний ногоо, 82.4 мянган га газарт тосны, 42.0 мянган га газарт тэжээлийн ургамал, нийтдээ 512.0 мянган га газарт тариалалт хийсэн. Урьдчилсан балансаар 441.9 мянган тонн үр тариа, үүнээс 420.0 мянган тонн буудай, 176.8 мянган тонн төмс, 91.2 мянган тонн хүнсний ногоо, 38.0 мянган тонн тосны ургамал, 80.4 мянган тонн малын тэжээлийн ургамал тус тус хураан авахаар байгаа юм.

Эх сурвалж: Montsame.mn

БУСАД МЭДЭЭ

Ипотекийн санхүүжилтэд 313 тэрбум төгрөг олгоод байна

Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд энэ оны эхний 9 сарын байдлаар нийт 313 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 4,447 иргэнд олгоод байна. Үүнээс:

-2019 оны 9-р сард Монголбанкны эх үүсвэрээс 16 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 243 иргэнд,

-Засгийн газрын эх үүсвэрээс 8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 130 иргэнд,

-Арилжааны банкууд өөрийн эх үүсвэрээс нийт 8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 111 иргэнд тус тус олгоод байгаа талаар Монголбанкнаас мэдээллээ.

Эх сурвалж: Монголбанк

АХБ-наас 101.5 сая ам.долларын зээл олгоно

Азийн хөгжлийн банк (АХБ)-наас Монгол Улсын эрүүл мэнд, дэд бүтцийн салбарыг хөгжүүлэхэд зориулж 101.5 сая ам.долларын зээл, 1.5 сая ам.долларын буцалтгүй тусламж олгох болжээ.

Уг зээлийн гэрээнд Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, АХБ-ны Монгол Улс дахь суурин төлөөлөгч Еланда Фернандез Ломмен нар гарын үсэг зурлаа.

Уг зээлийн 27 сая ам.доллароор “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийг хэрэгжүүлэх юм. Төслийн хүрээнд Бичигт, Боршоо боомтыг шинэчлэх, Алтанбулаг, Сүхбаатар боомтын барилга байгууламж, тоног төхөөрөмжийг сайжруулна. Мөн Гаалийн автоматжуулсан системийн өргөтгөл, гадаад худалдааны цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх аж.

“Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар, арчлалтын төслийн нэмэлт санхүүжилт” болох 60 сая ам.долларыг Хүйтний хөндий-Арвайхээрийн 58 км авто зам, Улаанбаатар-Дарханы 204 км авто замын их засвар, шинэчлэлтэд зориулна. Харин 16 сая ам.долларыг “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4”-ийн хүрээнд Сонгинохайрхан дүүрэгт барьж буй дүүргийн нэгдсэн эмнэлгийн ажлыг дуусгахад зарцуулах юм.

Хоёр хувийн хүүтэй, 25 жилийн хугацаатай зээл байх бөгөөд зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа таван жил байна.

Эх сурвалж: Montsame.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.